

# ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түнэл илч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2025/021/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Мөрөн сум  
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 88548896 Цахим хаяг: [mandakhnaranl@audit.gov.mn](mailto:mandakhnaranl@audit.gov.mn)  
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaa@yahoo.com](mailto:b_myadagmaa@yahoo.com)  
Аудитор Ц.Мөнхтуяа  
Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsGol@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/310  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

ТҮНЭЛ ИЛЧ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ЖАДАМБА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл илч ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 26 дүгээр тогтоолоор компанийн өмчлөлийг Түнэл сумын ИТХ-д шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзах, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 53,409.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 53,409.3 мянган төгрөгийн 7 алдааг зааруулж, нийцлийн аудиттай холбогдолтой 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүллээ.

**Бусад асуудлын хэсэг**

Түнэл илч ХХК нь тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөөг 2.3 хувиар давуулж биелүүлсэн ба зардлын гүйцэтгэл 107.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	789,006.81	6,352,826.08
1.1.2	Дансны авлага	1,624,788.00	2,056,839.70
1.1.6	Бараа материал	41,553,420.70	39,665,461.05
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>43,967,215.51</b>	<b>48,075,126.83</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	509,752,258.66	472,965,847.29
1.2.2	Биет бус хөрөнгө	24,758,549.75	24,758,549.75
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>534,510,808.41</b>	<b>497,724,397.04</b>
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>578,478,023.92</b>	<b>545,799,523.87</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,328,510.01	2,731,800.00
2.1.1.3	Татварын өр	16,554,573.03	32,924,831.23
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>22,883,083.04</b>	<b>35,656,631.23</b>
2.1.2	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	20,895,915.49	19,404,507.44
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>20,895,915.49</b>	<b>19,404,507.44</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>43,778,998.53</b>	<b>55,061,138.67</b>
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.3	<b>Өмч</b>		
2.3.1	-төрийн	178,862,641.08	178,862,641.08
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	174,175,791.10	174,175,791.10
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	293,679,624.00	308,479,624.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(112,019,030.79)	(170,779,670.98)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>355,836,384.31</b>	<b>490,738,385.20</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>578,478,023.92</b>	<b>545,799,523.87</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	333,596,581.08	344,528,275.82
2	Борлуулалтын өртөг	365,610,680.59	378,140,556.86
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(32,014,100)</b>	<b>(33,612,281.04)</b>
5	Хүүний орлого		24,395.35
8	Бусад орлого	915,854.33	1,491,408.05
10	Ерөнхий ба удирдлагын зардал	27,492,617.0	26,631,223.00
12	Бусад зардал	7,200.0	32,939.55
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(58,598,062.18)</b>	<b>(58,760,640.19)</b>
19	Орлогын татварын зардал	505,541.71	
20	<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	<b>(59,103,603.89)</b>	<b>(58,760,640.19)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(59,103,603.89)</b>	<b>(58,760,640.19)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(59,103,603.89)</b>	<b>(58,760,640.19)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641.1	174,175,791.1	279,059,624.0	(52,915,426.9)	579,182,629.28
2	Залруулсан үлдэгдэл	178,862,641	174,175,791.1	279,059,624.0	(52,915,426.9)	125,947,214.18
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(59,103,603.9)	(59,103,603.9)
5	Өмчид гарсан өөрчлөлт			14,620,000.0		14,620,000.00
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641.1	174,175,791	293,679,624	(112,019,030.8)	534,699,025.39
2	Залруулсан үлдэгдэл	178,862,641.1	174,175,791	293,679,624	(112,019,030.8)	66,843,610.29
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(58,760,640.2)	(58,760,640.2)
5	Өмчид гарсан өөрчлөлт			14,800,000.0		14,800,000.00
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641	174,175,791	14,800,000	(170,779,671.0)	490,738,385.20

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>367,002,701.20</b>	<b>378,458,321.45</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	367,002,701.20	378,363,926.10
1.1.6	Бусад мөнгөн орлого		94,395.35
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>369,644,195.12</b>	<b>372,894,502.18</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	111,440,858.00	105,685,212.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	37,426,849.48	37,363,542.79
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	82,722,922.50	54,463,675.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	38,891,311.80	52,358,810.55
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	62,902,310.00	87,594,350.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	21,484,518.84	23,124,746.49
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,872,000.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,903,424.50	12,304,165.35
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,641,493.92)</b>	<b>5,563,819.27</b>
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,641,493.92)</b>	<b>5,563,819.27</b>
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>3,430,500.73</b>	<b>789,006.81</b>
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>789,006.81</b>	<b>6,352,826.08</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
1	Халаалтын орлого	316,119.8	334,589.5	(18,469.7)	105.8
2	Цэвэр усны орлого	7,000.0	3,735.8	3,264.2	53.4
3	Халуун усны орлого	5,000.0	1,051.5	3,948.5	21.0
4	Хогны төлбөрийн орлого	6,600.0	418.0	6,182.0	6.3
5	Худгийн орлого	2,000.0	4,340.7	(2,340.7)	217.0
6	Бусад орлого		400.0	(400.0)	
<b>Орлогын дүн</b>		<b>336,719.8</b>	<b>344,535.5</b>	<b>(7,815.7)</b>	<b>102.3</b>
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	139,221.5	128,756.0	10,465.5	92.5
2	НДШимтгэлийн зардал	23,632.3	22,746.8	885.5	96.3
3	Нүүрс	42,075.0	36,761.5	5,313.5	87.4
4	Шатахуун	7,672.0	9,114.0	(1,442.0)	118.8
5	Тээврийн зардал	54,000.0	65,583.0	(11,583.0)	121.5
6	Гэрэл цахилгаан	38,200.0	52,358.8	(14,158.8)	137.1
7	Бичиг хэрэг	650.0	428.3	221.7	65.9
8	Цахилгаан холбоо	300.0	300.0		100.0
9	Албан томилолт	478.0	320.0	158.0	66.9
10	Хөдөлмөр хамгаалал	7,238.8	7,392.2	(153.4)	102.1
11	Төлбөр хураамж	6,639.1	17,074.6	(10,435.5)	257.2
12	ТУЗ зардал	3,307.0	3,307.0		100.0
13	Сэлбэгийн зардал	6,627.5	6,633.8	(6.3)	100.1
14	Ажилчдын нийгэм хангамж	3,000.0	123.7	2,876.3	4.1
15	Элэгдлийн зардал	51,586.4	51,586.4		100.0
16	Нохой устгал	1,000.0	810.0	190.0	81.0
<b>Нийт үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>385,627.6</b>	<b>403,296.1</b>	<b>(17,668.5)</b>	<b>104.6</b>
<b>Татварын өмнөх ашиг, /алдагдал/</b>		<b>(48,907.8)</b>	<b>(58,760.6)</b>	<b>(9,852.0)</b>	<b>120.1</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,409.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 53,409.3 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, нийцлийн аудиттай холбогдолтой 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Залруулсан алдаа:

- Хатангүнэл ХХК-аас худалдан авсан хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг бараа материалын дансанд орлого аваагүй шууд зардалд бүртгэсэн 1,488.5 мянган төгрөгийн залруулах бичилт хийсэн.
- Бичиг хэргийн материал бараа материалын дансанд орлого аваагүй шууд зардалд бичсэн 230.4 мянган төгрөгийн залруулах бичилт хийсэн.
- Хөвсгөл Баянцагаан ХХК болон Уужалга ХХК-аас худалдан авсан бараа материалыг бараа материалын дансанд орлого аваагүй шууд зардалд бичсэн 2,200.0 мянган төгрөгийн залруулах бичилт хийсэн.
- Мөнгөн гүйлгээний гүйлгээний тайланд буруу илэрхийлэгдсэн 10,545.6 мянган төгрөгийн залруулах бичилт хийсэн.
- Татварын ebarimt цахим системд 7,872.7 мянган төгрөгийн борлуулалтын орлого дутуу тайлагнасныг нөхөн шивүүлж залруулсан.
- Татварын ebarimt цахим системд 31,072.1 мянган төгрөгийн бараа материал болон ажил үйлчилгээнд төлсөн зардал e-баримт дутуу шивэгдснийг нөхөн шивүүлж залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 5.2 Албан шаардлага

- Түнэл илч ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөнд орлогыг 336,719.8 мянган төгрөгөөр, зардлыг 385,627.6 мянган төгрөгөөр, 48,907.8 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр батлагдсан зардлыг 17,668.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлээ.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15, зарлагын 8 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.10. “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” нийтэд мэдээлнэ заалттай нийцэхгүй бөгөөд Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан хугацааг баримтлан мэдээлж байх.

### 2. Ахмадын сангийн талаар

#### Илрүүлэлт:

Түнэл илч ХХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах.

### 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3,20.4 заалтад заасан ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн

жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй.

**Өгсөн зөвлөмж:**

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан болон зардлын дансанд буруу бичилт хийсэн	5	14,464.5			5	14,464.5	5	14,464.5		
Татварын Ebarimt системтэй зөрүүтэй борлуулалтын орлого, худалдан авалт	2	38,944.8			2	38,944.8	2	38,944.8		
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>53,409.3</b>			<b>7</b>	<b>53,409.3</b>	<b>7</b>	<b>53,409.3</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 23 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0.00					1	0.00
2024 оны бизнес төлөвлөгөөний батлагдсан зардлыг 17,668.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн	1	0.00			1	0.00		
Түнэл илч ХХК нь ахмадын сан байгуулаагүй	1	0.00					1	0.00

Төрийн хэмнэлтийн хуулийн 20-р зүйлд заасан мэдээллийг ил тод, цахимаар мэдээлээгүй.	1	0.00				1	0.00
Дүн	4	0.00			1	0.00	3 0.00



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 73/022704401

Мөрөн сум

ХАА.2025/016 / ИА.УТ.01044

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түнэл-Илч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түнэл-Илч ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний нийт зардлыг 17,668.5 мянган тогтоогоор хэтрүүлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохиж байгууллагаар батлуулан биелэлтийг хангах." гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдсан этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушвалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т "төсвийн орлого, зарлагын буруу тооцоолсон, төсвөт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй тооцож батлуулан биелэлтийг хангах, батлагдсан зардлын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түнэл-Илч ХХК-ийн захирал Г. Жадамба, нягтлан бодогч Б. Лхагва-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Д. МАНДАХНАРАН



6724070629